



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/10/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.open.audit.mn
Улаанбаатар хот
2024 он

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,	
тэргүүлэх аудитор:	Ч.Энхтуяа
Утас: 70363040	Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер:	Б.Батмөнх
Утас: 70363036	Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн:	Их наяд аудит ХХК-ийн
Захирал:	Х.Ариунзул
Утас: 11-450410	Цахим хаяг: ikhnayadaudit.@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	9
3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	10
4. Аудитын тайлан.....	
4.1 Ерөнхий зүйл.....	
4.2 Материаллаг байдал.....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
5. Аудитын илрүүлэлт.....	14
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	0

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТБОНОХБАХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ТУУЛЫН ХИШИГ” ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Э.ШИНСАНДАГ ТАНАА

2024.03.15 № СЭА-2024/10/НА-СТА-ОНА
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Туулын хишиг ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Туулын хишиг ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 2,687.7 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд төсвийн байгууллагаас 287,420.5 мянган төгрөг, айл өрхөөс 15,612.7 мянган төгрөг, аж ахуйн нэгжээс 12,529.7 мянган төгрөгийн орлого

бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг 41,061.6 мянган төгрөгөөр буюу 11.5 хувиар тасалсан байна.

Гүйцэтгэлээр 315,562.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 414,308.4 мянган төгрөгийн зардал гарган 98,745.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-т борлуулалтын орлого, өртгийн тооцоолол, хөрөнгө оруулалтын талаар нарийн тусгаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,732,805.07	1,545,739.97
1.1.2	Дансны авлага	74,779,627.88	73,526,505.37
1.1.4	Бусад авлага	6,266,330.30	
1.1.6	Бараа материал	15,107,099.99	6,518,100.99
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	97,885,863.24	81,590,346.33
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	501,228,281.76	475,167,509.91
1.2.2	Биет бус хөрөнгө	1,484,696,000.00	1,484,696,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,985,924,281.76	1,959,863,509.91
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,083,810,145.00	2,041,453,856.24
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	31,783,784.02	
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	29,935,944.47	53,948,481.67
2.1.1.4	НДШ-ийн өглөг		2,485,177.37
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	8,595,838.03	48,796,169.37
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	70,135,566.52	105,538,110.41
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		1,166,680.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		1,166,680.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн		106,704,490.41
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,958,488,000.00	1,958,488,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	164,604,304.98	164,604,304.98
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	160,000,000.00	160,000,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(269,597,726.50)	(348,343,239.615)
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,013,494,578.48	1,934,749,065.83
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,083,810,145.00	2,041,453,856.24

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	252,655,830.76	315,562,913.13
2	Борлуулалтын өртөг	232,559,664.24	352,381,663.81
3	Нийт ашиг(алдагдал)	20,096,166.52	(36,818,750.68)
5	Хүүний орлого		
8	Бусад орлого		20,000,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	36,212,878.08	56,622,856.97
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		5,303,905.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(16,116,711.56)	(78,745,512.65)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(16,116,711.56)	(78,745,512.65)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(16,116,711.56)	(78,745,512.65)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,958,488,000.00	164,604,304.98	160,000,000.00	(253,481,014.94)	2,029,611,290.00
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
Залруулсан үлдэгдэл	1,958,488,000.00	164,604,304.98	160,000,000.00	(253,481,014.94)	2,029,611,290.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(16,116,711.56)	(16,116,711.56)
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,958,488,000.00	164,604,304.98	160,000,000.00	(269,597,726.50)	2,013,494,578.48
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
Залруулсан үлдэгдэл	1,958,488,000.00	164,604,304.98	160,000,000.00	(269,597,726.50)	2,013,494,578.48
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(78,745,512.65)	(78,745,512.65)
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,958,488,000.00	164,604,304.98	160,000,000.00	(348,343,239.15)	1,934,749,065.83

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	268,184,287.12	362,876,700.82
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	268,184,287.12	599,200.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.6	Бусад мөнгөн орлого		362,277,500.82
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	290,889,108.38	349,468,165.92
1.2.1	Ажиллагчдад төлсөн	59,819,059.06	126,496,548.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	21,557,221.29	31,902,205.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	123,291,396.80	118,982,041.23
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	33,197,633.16	48,593,374.06
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	23,817,217.21	23,493,997.63
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	29,206,580.86	
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(22,704,821.26)	13,408,534.90
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн	(2,701,900.00)	(13,595,600.00)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,701,900.00	13,595,600.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,701,900.00)	(13,595,600.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(25,406,721.26)	(187,065.10)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,139,526.33	1,732,805.07
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,732,805.07	1,545,739.97

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2023 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
2	Нийт орлого	м/төг	252,655.8	356,624.5	315,562.9	21,061.6	94.1
	Үүнээс: Цэвэр борлуулалт	м/төг	252,655.8	356,624.5	315,562.9	21,061.6	94.1
3	Нийт зардал	м/төг	268,772.5	404,127.7	414,308.4	(10,180.7)	102.4
	Үүнээс:						
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	м/төг	232,559.7	360,786.8	352,381.7	(8,405.1)	97.8
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	36,212.8	48,645.0	61,926.7	13,281.7	127.3
	с) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг					
4	Цэвэр ашиг, алдагдал	м/төг	(16,116.7)	(47,503.2)	(98,745.5)	(51,242.3)	207.8

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Туулын хишиг” ОНӨААТҮГ нь “*Орчин үеийн техник технологи нэвтрүүлэн байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл үйлчилгээ явуулж хэрэглэгчдийг дулааны эрчим хүч, ахуйн хэрэглээний улсын стандарт хангасан цэвэр ус олборлон түгээх, хэрэглээний улмаас гарсан бохир усыг татан зайлуулах ажлыг байнгын хэвийн найдвартай хангаж, эдийн засгийн алдагдлыг бууруулах замаар салбартаа тэргүүлэгч байгууллага болно*” гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

“Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын төв дэх төсвийн байгууллагуудын дулаан хангамж, тохижилт, орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, зарим засвар үйлчилгээг харилцан гүйцэтгэх, хяналт тавих,
- Сумын төв, хөдөөд газар тариалан эрхлэх, дулаан цэвэр усаар хангах иргэн, байгууллагатай гэрээ хийх, ашиглалтын төлбөр тооцоо хийх,
- Орон нутгийн өмчийн техник бусад хэрэгслээр төсвийн байгууллагад захиалгат үйлчилгээг мөн тогтоосон үнэ тарифаар үйлчилгээ үзүүлэх гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Туулын хишиг” ОНӨААТҮГ-ыг сумын ИТХ-ын 2009 оны 51 дүгээр тогтоолоор байгуулсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх”, 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д “*Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах***”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “*Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих***” гэсэн заалттай нийцэж байна.

“Туулын Хишиг ” ОНӨААТҮГ нь Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль Нийгмийн даатгалын багц хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТБОНӨХБАҮХА тухай хууль, Эрчим хүчний тухай хууль зэрэг хуулиудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул байна гэж үзлээ.

"Туулын хишиг" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд Орхонтуул сумын ИТХ, ЗДТГ, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Туулын хишиг" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

"Туулын Хишиг" ОНӨААТҮГ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий борлуулалтын орлого, өртгийн тооцоолол, хөрөнгө оруулалтын талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

"Туулын хишиг" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 42,356.3 мянган төгрөгөөр буюу 2.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,732.8	1,545.7	(187.1)
Авлага	81,045.9	73,526.5	(7,519.4)
Бараа материал	15,107.1	6,518.1	(8,589.0)
Үндсэн хөрөнгө	501,228.3	475,167.5	(26,060.8)
Биет бус хөрөнгө	1,484,696.0	1,484,696.0	-
Нийт хөрөнгө	2,083,810.1	2,041,453.8	(42,356.3)
Богино хугацаат өр төлбөр	70,315.5	126,704.5	56,389.0
Эздийн өмч	1,958,488.0	1,958,488.0	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	164,604.3	164,604.3	-
Эздийн өмчийн бусад хэсэг	160,000.0	160,000.0	-
Хуримтлагдсан ашиг	(269,597.7)	(368,343.2)	(98,745.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,083,810.1	2,041,453.8	(42,356.3)

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 73,526.5 мянган төгрөг болж 7,519.4 мянган төгрөгөөр буурсан нь ажилчдаас авах авлагыг бүрэн барагдуулсан. Нийт авлагын 5.0 хувь буюу 3,615.7 мянган төгрөгийг айл өрхөөс авах усны, 54.3 хувь буюу 39,942.6 мянган төгрөгийг төсвийн байгууллага, аж ахуйн нэгжээс авах усны, 3.7 хувь буюу 2,700.0 мянган төгрөгийг хувь хүнээс авах авлага, 37.0 хувь буюу 27,268.1 мянган төгрөгийг нэр тодорхойгүй авлага эзэлж байна. Авлагын үлдэгдэлд хугацаа хэтэрсэн, эзэн холбогдогч тодорхойгүй, насжилт өндөртэй төсвийн байгууллагаас авах 27,268.1 мянган төгрөгийн найдваргүй авлага байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 6,518.1 мянган төгрөг болж 8,589.0 мянган төгрөгөөр буурсан нь 2022 оны түүхий эд материалын үлдэгдлийг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 475,167.5 мянган төгрөг болж 26,060.8 мянган төгрөгөөр буурсан нь өөрийн хөрөнгөөр 13,595.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, компьютер худалдан авч, Орхонтуул сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 83 дугаар тогтоолоор 8,730.0 мянган төгрөгийн хөрөнгө акталсан ба тайлант онд 59,489.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос,
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 126,704.5 мянган төгрөг болж 56,389.0 мянган төгрөгөөр өссөн нь урьдчилж орсон орлого 20,000.0 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын 12,436.6 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн 2,485.2 мянган төгрөгийн өглөг тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Нийт өр төлбөрийн 2.3 хувь буюу 2,485.2 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн, 35.5 хувь буюу 37,496.7 мянган төгрөгийг татварын, 8.1 хувь буюу 8,595.8 мянган төгрөгийг дансны өр төлбөр, 54.1 хувь буюу 56,960.4 мянган төгрөгийг цалингийн өр төлбөр эзэлж байна.

3.5 Техник, эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу "Туулын хишиг" ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

"Туулын хишиг" ОНӨААТҮГ-ын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулж тайлант оны нийт орлогыг 356,624.5 мянган төгрөгөөр, нийт зардлыг 404,127.7 мянган төгрөгөөр, алдагдлыг 47,503.2 мянган төгрөгөөр төсөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 315,562.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 414,308.4 мянган төгрөгийн зардал гарган, 98,745.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тайлант онд төсвийн байгууллагаас 287,420.5 мянган төгрөг, айл өрхөөс 15,612.7 мянган төгрөг, аж ахуйн нэгжээс 12,529.7 мянган төгрөгийн зэрэг нийт 315,562.9 мянган төгрөг орлого бүрдүүлж, төлөвлөснөөс 41,061.6 мянган төгрөг буюу 11.5 хувиар тасарсан нь орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн Спорт заал ашиглалтад ороогүйгээс шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 414,000.1 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 10,180.7 мянган төгрөг буюу 2.4 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь шатахуун, сэлбэг материал болон цахилгааны төлбөрийг 2022 онтой дүйцүүлэн төлөвлөснөөс шалтгаалсан байна.

Тайлант онд цэвэр алдагдал 78,437.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 30,934.0 мянган төгрөгөөр илүү байгаа нь орлого, зардлын гүйцэтгэлээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу "Туулын хишиг" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд "Туулын хишиг" ОНӨААТҮГ түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Их наяд Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Мөнхзул, аудитор М.Энхтуул нар гүйцэтгэж, хяналтыг захирал, чанарын хяналтын менежер Х.Ариунзул, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын

аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

"Туулын хишиг" ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангаа Их наяд аудит ХХК-д 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн 268,772.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,687.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд орлогын 93,830.7 мянган төгрөг, зарлагын 7,535.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд 118,437.1 мянган төгрөгийн түүхий эд материал болох нүүрсийг “Алтан очир” ХХК, “Гоулд хангай” “Шарын гол” ХХК-тай шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход

баримтлах босго үнийн 2 дахь “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа 20.0 сая төгрөг” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж байх албан шаардлага хүргүүлэх.

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Туулын Хишиг” ОНӨААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,*
- *Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,*
- *Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан гэх мэт.*

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөг, цалин, орлогын дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн. Аудитаар нийт 121,641.3 мянган төгрөгийн 6 алдаа илэрснээс жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үзэхэд алдааг залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 130,752.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлснийг 67.1 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,170.0	1	1,170.0	100.0
Албан шаардлага	2	83,619.5	2	41,809.7	50.0
Зөвлөмж	2	45,963.2	-	-	-
Нийт дүн	5	130,752.7	3	42,979.7	67.1

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дараагийн аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгийн тооллого хийж, биет тест хэрэгжүүлэх горимыг бүрэн хэрэгжүүлээгүй учир дараагийн аудитаар тулган шалгах нь зүйтэй юм.

- Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг үндсэн үйл ажиллагааны үр дүнгээр алдагдалтай ажиллахаар төлөвлөж байгаа нь үйлдвэрийн газар өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан ажиллах чадваргүй нөхцөл байдалд хүргэж байна. Цаашид үйлдвэрлэлийн удирдлага, менежментийг сайжруулах замаар үйлдвэрлэлийн үр дүнгээр ашиг хүртэх нөхцөл боломж бий эсэх, шаардлагатай бол бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх эсэх асуудлыг гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгаж, дүгнэлт өгөх нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулга

Аудитаар нийт **9,590.6** мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- НӨАТ-ын тайлангийн борлуулалтын орлогын 7,987.1 мянган төгрөгийг давхардуулан бүртгэсэн,
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд ажилчдын 1,603.6 мянган төгрөгийн цалинг илүү тусгасан байна. Эдгээр нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах ;"* гэсэн заалттай нийцээгүй байна.

Аудитаар нийт **94,010.9** мянган төгрөгийн зөрчил илэрч 3 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр дараах зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд :

1.Тайлант онд **15,500.5** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь *"зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх"*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь *"Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм..."* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.Харилцагч нь тодорхой бус, олон жил дамнасан, насжилт өндөртэй **27,268.1** мянган төгрөгийн авлагыг шийдвэрлэх, шаардлагатай бол холбогдох байгууллага, албан тушаалтанд хандаж данс бүртгэлээс хасах талаар арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх *"Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг*

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

үйлдвэрийн газрын Захирал удирдана" , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь " Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах"...., гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3. Боловсруулж, батлуулсан 2023 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан орлогын төлөвлөгөөг **41,061.6** мянган төгрөгөөр тасалж, зардлыг **10,180.7** мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан **биелэлтийг хангах**" гэсэн заалт болон сумын Засаг даргын баталсан 2023 оны " Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө"-г зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрлэлийн удирдлага, менежментийг сайжруулах, "Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө"-г бодитоор төлөвлөх замаар батлагдсан орлого, зардлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
НӨАТ-ын тайлангийн борлуулалтын орлогыг давхардуулан бичсэн	1	7,987.1			1	7,987.1	1	7,987.1				
Нийгмийн даатгалын тайланд ажилчдын цалинг илүү тусгасан	1	1,603.6			1	1,603.6	1	1,603.6				
Дүн	2	9,590.6			2	9,590.6	2	9,590.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн цахим баримтыг дутуу бүрдүүлсэн.	1	15,500.5			1	15,500.5						
Харилцагч нь тодорхой бус олон жилийн насжилттай авлага, өглегийг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй	1	27,268.1			1	27,268.1						
Баталсан орлого, зардлын төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй	1	51,242.3			1	51,242.3						

Дүн	3	94,010.9	3	94,010.9			
-----	---	----------	---	----------	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 93,830.7 мянган төгрөгийн орлогын, 7,535.0 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээ мэдээлээгүй	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй.	1	118,437.1			1	118,437.1		
Дүн	1	118,437.1			1	118,437.1		
Нийт дүн	2	118,437.1			1	118,437.1	1	-